



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 31 өдөр


Дугаар A/12

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.1.1, 11.2.1, 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Иргэн Б.Түвшинтулга, Д.Отгонцагаан, Ш.Дархисүрэн, А.Туяацэцэг, Н.Жаргалсайхан нарын нэхэмжлэлтэй, иргэний хэргийн материалтай танилцах, нэхэмжлэлийн шаардлага гардан авах ажлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нарыг Сэлэнгэ аймагт 2023 оны 02 дугаар сарын 02-04-ний өдөр албан томилолтоор ажиллуулсугай.
- Албан томилолтоор ажиллах удирдамжийг 1 дүгээр, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
- Албан томилолтын тайланг ажлын 3 өдөрт багтаан танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нарт даалгасугай.
- Албан хаагчдын унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Ц.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын
31 өдрийн 1 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Албан томилолтын ажлын зорилго, чиглэл:

Иргэн Б.Түвшинтулга, Д.Отгонцагаан, Ш.Дархисурэн, А.Туяацэцэг,
Н.Жаргалсайхан нарын нэхэмжлэлтэй, иргэний хэргийн материалтай танилцах,
нэхэмжлэлийн шаардлага гардан авах.

Албан томилолтоор ажиллах хугацаа:

2023 оны 02 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд ажлын хуанлийн 3 хоногийн
хугацаанд гүйцэтгэнэ.

Албан томилолтоор ажиллах газар:

Сэлэнгэ аймаг

Хоёр. Албан томилолтоор хийж гүйцэтгэх ажил үүрэг

Иргэн Б.Түвшинтулга, Д.Отгонцагаан, Ш.Дархисурэн, А.Туяацэцэг,
Н.Жаргалсайхан нарын нэхэмжлэлтэй, иргэний хэргийн материалтай танилцах,
нэхэмжлэлийн шаардлага гардан авах.

.....000.....

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 01. дүгээр сарын
31 өдрийн 12 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Орон нутагт томилолтоор ажиллах зардлын төсөв

№	Чиглэл	Тоо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/	Хянасан
Тээврийн зардал / Вагон 1 хүн нэг талдаа 44000 төг/ Томилолт 2 албан хаагч хуанлийн 3 хоног вагон.						
1	Улаанбаатараас Сэлэнгэ аймаг, Сэлэнгэ аймгаас Улаанбаатар хот	290x2	км	44000	176,000	176,000
2	Томилолтын зардал	2	хоног	118000x3	354000x2	708,000
Нийт зардал						884000

Тоогоор 884000 төгрөг, үсгээр / найман зуун наян дөрвөн мянга/ төгрөг.

Тайлбар: Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалаар батлагдсан томилолтын зардлын нормативыг үндэслэн тооцов.

.....000.....